

JICA関西ガイド(モンゴル語)



ЖАЙКА Кансай ХӨТӨЧ

Кансай Төв
Японы Олон улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
(ЖАЙКА Кансай)

(2019 оны 5-р сарын байдлаар)

Гарчиг

I . Байршил	1
II . Давхрын схем болон байгууламжууд	2
III . Үйлчилгээ	5
IV . Дүрэм, журам	9
V . Эмнэлгийн тусламж үйлчилгээ	11
VI . Онцгой байдлын процедур	12
VII . Харилцааны хөтөлбөрүүд - Спорт, Японы соёл	15

I . Байршил

1. Хаяг Хиого, Кобэ, Чю-о кү, Вакино-хама кайган доори 1-5-2
651-0073 Япон


2. Утасны дугаар

ЖАЙКА Кансай, Ресепшн: +81-78-261-0341



3. Факсны дугаар

ЖАЙКА Кансай, Офис: +81-78-261-0465


4. Байршлын газрын зураг




II. Давхрын схем болон байгууламжууд




3-р давхар



4-р давхар





Давхар	①	②
13	Нэг хүний өрөө 1301-1310	Нэг хүний өрөө 1311
12	Нэг хүний өрөө 1201-1210	Хоёр хүний өрөө 1211
11	Нэг хүний өрөө 1101-1110	Нэг хүний өрөө 1111
10	Нэг хүний өрөө 1001-1010	Хоёр хүний өрөө 1011
9	Нэг хүний өрөө 901-910	Тэргэнцэртэй хүнд зориулсан хоёр хүний өрөө 911
8	Нэг хүний өрөө 801-810	Тэргэнцэртэй хүнд зориулсан хоёр хүний өрөө 811
7	Нэг хүний өрөө 701-710	Ачаа хадгалах өрөө
6	Нэг хүний өрөө 601-610	Ачаа хадгалах өрөө
5	Нэг хүний өрөө 501-510	Компьютерийн өрөө

Гал түймрээс сэргийлэх үүднээс, зочдын өрөөнд дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- Тамхи татах
- Хоол хийх
- Аливаа задгай гал хэрэглэх
- Индүү хэрэглэх

III. Үйлчилгээ

1. ЖАЙКА-гийн ажлын цаг

◆ Ажлын өдрүүдэд:

09:30 - 12:30

13:15 - 17:45

◆ Бямба, Ням, Үндэсний баярын өдрүүдэд:

Амарна

2. Гуанз

	Онгойх цаг	Сүүлчийн захиалга	Хаах цаг
Өглөөний цай	07:00 (Ажлын өдрүүдэд)	8:30	9:00
	07:30 (Бямба, Ням, Үндэсний баярын өдрүүдэд)	9:30	10:00
Үдийн хоол	11:30	13:30	14:00
Оройн хоол	17:30	20:30	21:00

Тэмдэглэл: Халал хоолоор үйлчилнэ.

Өглөөний цайны үнэ буудлын үнэнд хамрагдсан. Өглөө бүр гуанзанд байршуулсан бүртгэлийн хуудсанд гарын үсгээ зурна уу.

ЖАЙКА-гийн гуанз нь өөртөө үйлчлэх хэлбэртэй.

Ширээнүүд дээр тавьсан зүйлс болон амтлагчийг гуанзнаас гадагш авч гарахаас татгалзана уу.

Зочдын өрөөгөөр үйлчлэхгүй.

Хоолны карт

ЖАЙКА Кансайд байрлахаар бүртгүүлэх үед тань танд "Хоолны карт" өгнө.

Хоолны карт нь, таны ЖАЙКА Кансайд байрлахаар товлогдсон нийт хоногийн тоогоор, нэг хоногт 1,100 иенээр тооцоолон, урьдчилан цэнэгдлэгдсэн байх болно.

* Мөнгөн дүн нь, урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөх магадлалтай.

- (1) Хоолны картыг та өөрөө хариуцан хадгална уу. Хоолны картыг дахин ОЛГОХГҮЙ.
- (2) Хоолны картыг ямар ч тохиолдолд бусдад дамжуулж болохгүй.
- (3) Хоолны карт нь зөвхөн ЖАЙКА төвийн гуанзанд л ашиглах боломжтой.
- (4) Хэрэглэж дууссан хоолны карт (0 иен)-аа Ресепшнд буцааж өгнө үү.
- (5) Хоолны картанд үлдэгдлийг тэмдэглэх зайгүй болсон тохиолдолд, эсвэл ямар нэгэн гэмтэл / ослын улмаас карт тань хэрэглэгдэхгүй болсон тохиолдолд, Ресепшнд хоолны картыг дахин гаргуулах хүсэлт тавина уу.
- (6) ЖАЙКА төвөөс гарахдаа, хоолны картыг Ресепшнд буцааж өгнө үү. Хоолны картны үлдэгдэл мөнгийг бэлэн мөнгөөр солих юм уу буцааж авах боломжгүй. Хоолны картаар кассны зүүн талд байршуулсан бэлэг дурсгалын зүйлс, хөнгөн зууш болон ундаа худалдан авах боломжтой.

3. Ресепшн (Утас: (078) 261-0341, Дотуур дугаар: # 2100)

- (1) Үйлчилгээний цаг 07:00-23:00 (Төв хаалга 23:00 цагт хаагдана.)

Хаалга нээлттэй байх цаг: Төв хаалга 07:00-23:00

Далайн эрэг талын хаалга 07:00-21:00

23:00 цагаас хойш орох тохиолдолд, Ресепшнд утсаар, эсвэл зориулалтын маягтыг хураалгаж, урьдчилан мэдэгдэнэ үү.

- (2) Буудалд бүртгүүлэх 15:00

- (3) Буудлаас гарах 10:00

- (4) Түлхүүр 2 төрлийн түлхүүртэй.

1) Өрөөний түлхүүр: Өрөөнөөс гарах бүртээ өрөөнийхөө хаалгыг гараар түгжинэ үү. Өрөөний цоож автомат биш.

2) Аюулгүйн түлхүүр: Өрөөний түлхүүрэнд зүүсэн хар чипийг, 5-13 давхрын лифт хүлээх талбайгаас зочдын өрөө рүү нэвтрэх аюулгүйн хаалгыг онгойлгоход хэрэглэнэ. Түлхүүрүүдийг салгаж болохгүй ба гадагшаа гарахдаа түлхүүрээ Ресепшн дээр үлдээнэ үү.

4. Үйлчилгээ

- (1) Утас

Дотоодын болон улс хоорондын дуудлагыг Ресепшнээр дамжуулан, өрөөндөө хүлээн авах боломжтой. Коллект дуудлага буюу хүлээн авагч нь төлбөрийг нь төлдөг дуудлагаар үйлчлэхгүй. Өрөө хооронд ярихад, өрөөний дугаарыг хийх ба үнэ төлбөргүй ярих боломжтой.

Гадагшаа ярих 2 арга байна.

1) 1-р давхрын нийтийн утас ашиглах.

2) Зочдын өрөөний утсыг ашиглах. (Ресепшнээс 1,000 иенээр BRASTEL урьдчилсан төлбөртэй карт худалдан авах боломжтой.)

* Факс хүлээн авах үйлчилгээг, зөвхөн ЖАЙКА-гийн сургалтанд оролцогчдод үзүүлнэ.

- (2) Шуудан, илгээмж

Ресепшн дээрээс шуудангийн марк худалдан авах, илгээмж явуулах боломжтой.

- (3) Халуун усны үйлчилгээ

Ванны өрөөний (шүршүүр) халуун ус нь 06:00 - 24:00 цагийн хооронд гарна.

- (4) Өрөөний цэвэрлэгээ

Өрөөний цэвэрлэгээ зөвхөн ажлын өдрүүдэд хийгдэнэ. Ор, хөнжил, дэрний даавууг долоо хоногт нэг удаа солино.

- (5) Зочдын өрөөн дэх интернет холбоо

Мэдээллийн товхимлын "Интернетэд холбогдох" болон "Төлөөлөх серверийн тохиргоог арилгах арга"-ыг харна уу.

- (6) Хөргөгч

Таны өрөөнд тавигдсан хөргөгчинд хөлдөөх тасалгаа байхгүй.

Эрүүл ахуйн үүднээс, буудлаас гарах үедээ хөргөгчөө суллана уу.

- (7) Бусад үйлчилгээ

Дараах зүйлсийг Ресепшнээс авч хэрэглэх боломжтой. Үүнд:

1) Үсний сэнс

2) Индүү

3) Унадаг дугуй (Зөвхөн ЖАЙКА-гийн сургалтанд оролцогчдод). Мэдээллийн товхимлын "Унадаг дугуй унахаас тань өмнө анхааруулах зарим зүйлс"-ийг харна уу.

5. Байгууламж

Дараах байгууламжуудыг ашиглахад, Ресепшнд урьдчилан бүртгүүлэх ба, эсвэл захиалга өгөх шаардлагатай. Нэг удаагийн бүртгэл / захиалгаар дээд тал нь 2 цаг ашиглах боломжтой.

Давхар	Байгууламж	Ажиллах цаг
1 дав.	Номын сан	09:30-18:00 (Зөвхөн ажлын өдрүүдэд)
2 дав.	Биеийн тамирын заал (Ширээний теннис, Агаарын теннис, Сагсан бөмбөг, Волейбол)	08:00-22:00
3 дав.	Эмнэлгийн зөвлөгөө өгөх өрөө (Зөвхөн ЖАЙКА-гийн сургалтанд оролцогчдод)	11:00-18:00 (Даваа, Мягмар, Пүрэв, Баасан) 15:00-18:00 (Лхагва)
4 дав.	Теннисний талбай	12:00-22:00 (Ажлын өдрүүдэд) 08:00-22:00 (Бямба, Ням, Үндэсний баярын өдрүүдэд)
5 дав.	Компьютерийн өрөө (Зөвхөн ЖАЙКА-гийн сургалтанд оролцогчдод)	07:00-24:00 <Бүртгүүлэх шаардлагатай.>

6. Угаалгын машин, индүү, богино долгионы зуух

Угаалгын машин болон хувцас хатаагч, богино долгионы зуух (печь) 5-13 давхрын "Ахуйн хэрэглээний өрөө"-нд байх ба эдгээрийг 07:00-23:00 цагийн хооронд ашиглах боломжтой. "Ахуйн хэрэглээний өрөө"-нд тавьсан угаалгын нунтгийг чөлөөтэй хэрэглэж болно. 6-7 давхрын угаалгын машин болон хувцас хатаагч нь зөвхөн эмэгтэйчүүдэд зориулсан болно. Уурын индүүг Ресепшнээс авч хэрэглэх боломжтой. Индүүг зөвхөн индүүний ширээ байрлуулсан "Ахуйн хэрэглээний өрөө"-нд хэрэглэнэ үү. Гал түймрээс сэргийлэх үүднээс, зочдын өрөөнд индүү хэрэглэхийг хатуу хориглоно.

7. Ундааны автомат машин

Ундааны автомат машин 1, 3, 4-р давхруудад байгаа.
Мөсний машин "Ахуйн хэрэглээний өрөө"-нд байгаа.

8. Үнэт эд зүйлс

Үнэт эд зүйлсээ зочдын өрөөн дэх сэйф хайрцганд хадгална уу.
ЖАЙКА Кансай нь таны хувийн эд зүйлс гээгдсэн, эвдэрч гэмтсэн эсвэл хулгайлагдсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

9. Материал хувилах

2-р давхарт хувилагч машин байгаа.
Шаардлагатай үедээ Ресепшнээс хувилагч машины картыг авч хэрэглэнэ үү.

10. Крантны ус

Зочдын өрөөний крантны усыг шууд уух боломжтой. Мөн, 3-р давхрын усны машинаас хүйтэн ус авч хэрэглэх боломжтой. Өөрийнхөө аяга юм уу савыг авч очин, хүйтэн ус хийж авна уу.

11. Бусад

- (1) Онцгой тохиолдолд дүрвэх зам
Онцгой тохиолдолд дүрвэх замыг урьдчилан мэдэж авна уу. Онцгой тохиолдолд дүрвэх замын тэмдгийг зочдын өрөөнүүдийн хаалганы дотор талд харуулсан байгаа.

(2) Яаралтай тохиолдлын дуудлага

Яаралтай тохиолдолд, цаг алдалгүй Ресепшн рүү ярина уу. (Дотуур дугаар: 2100)

(3) Хог хаягдлыг ялгаж хаях болон цахилгаан хэмнэх

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах үүднээс, хог хаягдлын 3R (Reduce (бууруулах), Reuse (дахин ашиглах) болон Recycle (дахин боловсруулах)) болон нөөцийг хэмнэхэд хандуулж буй таны анхааралд талархахын зэрэгцээ хогийг ялгаж хаях, ус болон цахилгааныг хэмнэхэд бидэнтэй хамтран ажиллаж буй танд баярлалаа.

IV Дүрэм, журам

1. Журам

- (1) Сургалтын бүх хугацааны турш ЖАЙКА-гийн ажилтан, Сургалтын лидер болон Сургалтын координатор нарын зааврыг дагах шаардлагатай.
- (2) Таны Японд оршин суух хугацааг сунгах боломжгүй. ЖАЙКА-гаас заагдсан нислэгийн хуваарийн дагуу нутаг буцах шаардлагатай.
- (3) Аливаа улс төрийн, ашгийн болон шашны чанартай үйл ажиллагаанд холбогдохыг хориглоно.
- (4) Сургалтаа амжилттай дүүргэснийг тохиолдуулан, ЖАЙКА-гаас танд сертификат олгох ба диплом олгохгүй.

2. Буудалд байрлахтай холбогдох дүрэм, журам

- (1) **ЖАЙКА Кансай-ын төв хаалга 23:00 цагт хаагдана.**
23:00 цагаас өмнө харьж ирнэ үү.

Хэрвээ та дээр дурьдсан цагаас өмнө харьж ирэх боломжгүй бол, аль болох эрт Ресепшн рүү холбоо барьж, хаана байгаа, хэдэн цагт харьж ирэх боломжтойгоо мэдэгдэнэ үү.

Үүнээс гадна, **23:00 цагаас хойш гадагшаа гарах боломжгүй**г анхаарна уу.

- (2) Хүссэн тохиолдолд, зөвхөн **Баасан, Бямба гаригууд болон баярын өдрийн өмнөх өдрүүдэд** гадуур хонох боломжтой. Гадуур хонох хүсэлтэй хүмүүс урьдчилан "Гадуур хонох тухай мэдэгдэл хуудас"-ыг бөглөн, Ресепшнд хураалгах шаардлагатай.
- (3) Гал түймрээс сэргийлэх үүднээс, зочдын өрөөнд цахилгаан индүү, тасалгааны халаагуур, зуух, талх шарагч болон бусад халаах төхөөрөмж хэрэглэхийг хориглоно.
Хэт халахаас сэргийлэх үүднээс, чийдэнгийн бүрхүүл дээр алчуур болон бусад зүйлсийг тавихаас татгалзана уу.
- (4) 4-р давхрын теннисний талбайн өмнөх зориулалтын газраас бусад газарт тамхи татахыг хориглоно.
- (5) Гадны зочид сургалтанд оролцогчдын байрлаж буй давхар руу орох боломжгүй.
Гадны зочидтой уулзахдаа, зөвхөн 1-р давхрын хүлээлгийн танхим юм уу гуанзанд уулзана уу.
- (6) 22:00 цагаас хойш, чанга дуугаар ярих, радио/CD-г чанга дуугаар тавих гэх мэт бусдад саад төвөг учруулах үйлдэл хийхийг хориглоно.
- (7) Өрөөний тавилга, тоног төхөөрөмжийг байсан байрлалаас нь хөдөлгөхийг хориглоно.
- (8) Барилгын хануудад зураг, цаас болон бусад зүйлсийг нааж, эсвэл бохирдуулан гэмтээж болохгүй.
- (9) ЖАЙКА-гаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр, ЖАЙКА Кансай доторх мэдээллийн самбар болон бусад газарт зарлал наахыг хориглоно.
- (10) ЖАЙКА Кансайд ямарваа амьтан, үнэртэй зүйл, зэвсэг, дэлбэрэх бодис, галын аюултай бодис, овор ихтэй зүйл болон эдгээртэй ижил төстэй бусад зүйлсийг авч орохыг хориглоно.
- (11) Таны гэр бүлийн ЯМАР ч гишүүн ЖАЙКА Кансайд хонохыг зөвшөөрөхгүй.

3. Гэмтээсэн, гэж үрэгдүүлсэн зүйлсийн хохирлын нөхөн барагдуулалт

Танаас шалтгаалан, ЖАЙКА-гийн байгууламж юм уу тоног төхөөрөмж гэмтсэн, гэж үрэгдсэн тохиолдолд, үүссэн хохирлыг та өөрөө нөхөн барагдуулах шаардлагатай.

4. Компьютерийн өрөөг хэрэглэх журам (Зөвхөн ЖАЙКА-гийн сургалтанд оролцогчдод зориулсан)

Компьютерийн өрөөг ашиглахад, Ресепшн дээр "Компьютерийн өрөө ашиглах өргөдөл"-ийг бөглөн, захиалга өгөх боломжтой. Захиалга өгсөн цагтаа компьютер ашиглаж эхлэхээсээ өмнө, урьдчилан Ресепшнээс ЗӨВШӨӨРЛИЙН КАРТ авна уу.



	Компьютерийн өрөө (5-р давхар)
Ажлын цаг	07:00 - 24:00 Ресепшн дээр 23:00 цаг хүртэл захиалга хүлээн авна. Компьютерийн өрөөг 24:00 цагт хааж, өдөр тутамд вирусын шалгалт хийх ба 24:00 цагаас хойш ашиглах боломжгүй.
Компьютер	Компьютер ашиглахдаа, эхлээд монитормыг нь асааж, дараа нь компьютерээ асаана уу. Хэрэглэж дууссаныхаа дараа, эхлээд компьютерээ унтрааж, дараа нь монитормыг нь унтраана уу.
Принтер	Принтер хэрэглэхээсээ өмнө асааж, хэрэглэж дууссаныхаа дараа унтраана уу.
Хэвлэж авах	Зөвхөн шаардлагатай үед л хэвлэж гаргана уу. Хэвлэх цаасыг Ресепшнээс авах боломжтой.

5. Хувийн компьютерээрээ зочдын өрөөнд интернетэд холбогдох

Хувийн компьютерээрээ зочдын өрөөнд интернетэд холбогдох боломжтой. ВИРУСЫН ЭСРЭГ СОФТВЭЙР суулгаж, USB буюу флаш диск хэрэглэхдээ, вирусын шалгалт хийхийг танаас хүсье. ВИРУСЫН ЭСРЭГ СОФТВЭЙР суулгах болон интернетэд холбогдох талаар дэлгэрэнгүй мэдээллийн тухай, таны өрөөнд тавьсан зааврыг харна уу. Хэрвээ танд интернетэд холбогдоход ямар нэгэн асуудал гарвал, Ресепшнд хандана уу. (Бид Apple компанийн компьютерт тусламж үзүүлэх боломжгүй.)

6. Утасгүй, LAN-аар холбогдох

ЖАЙКА Кансай дотор үнэ төлбөргүй Wi-Fi үйлчилгээг ашиглах боломжтой. ЖАЙКА Кансай-ын "Мэдээллийн товхимол" дахь "Wi-Fi-д холбогдох арга"-ыг харна уу.

V. Эмнэлгийн тусламж үйлчилгээ

ЖАЙКА-гийн сургалтанд оролцож буй бүх оролцогч Японд оршин суух албан ёсны бүх хугацаандаа эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжтой. ЖАЙКА-гийн сургалтанд оролцогч танд ямарваа нэг эрүүл мэндийн асуудал гарвал, юуны өмнө Эрүүл мэндийн координатор, Сургалтын координатор, ЖАЙКА-гийн ажилтан, эсвэл Ресепшнээс зөвлөгөө авахыг санал болгож байна

1. Эрүүл мэндийн карт

(1) Бүх оролцогчдод ЖАЙКА-гаас нэгдсэн журмаар хамруулсан даатгал үйлчилнэ.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсаныг гэрчлэх Эрүүл мэндийн картыг "Брифинг"-ийн үеэр оролцогч бүрт өгнө. Энэхүү карт нь таны оршин суух хугацаанд эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад хэрэглэгдэнэ. Эмчилгээний зардал нь, эрүүл мэндийн даатгалын гэрээний заалтын дагуу төлөгдөнө.

(2) Дараах эмчилгээний зардлуудад Эрүүл мэндийн карт ҮЙЛЧЛЭХГҮЙ. Үүнд :


- 1) санаатай хууль бус үйлдлийн улмаас үүссэн өвчин болон бэртэл гэмтэлд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ
- 2) урьд өмнөөс байсан өвчинд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ
- 3) нэн яаралтай шаардлагагүй гажиг засах мэс засал
- 4) гоо сайхны мэс засал
- 5) дахрлаажуулалт, тогтсон эрүүл мэндийн үзлэг, вакцинжуулалт
- 6) жирэмслэлт ба/эсвэл төрөлттэй холбоотой, мөн жирэмслэлт ба/эсвэл төрөлтөөс шалтгаалан авах эмнэлгийн аливаа тусламж үйлчилгээ
- 7) нэн яаралтай шаардлагагүй шүдний эмчилгээ
- 8) гажиг засах нүдний шил ба/эсвэл контакт линз худалдаж авах, эсвэл засуулах
- 9) эмчийн жоргүй эм
- 10) осол гарсан өдрөөс хойш 180-аас дээш өдөр өнгөрсөн тохиолдлын эмнэлгийн тусламж үйлчилгээ

(3) Хэрвээ эмнэлэг юм уу клиник дээр Эрүүл мэндийн картыг хүлээн авахгүй бол, зардлыг нь өөрөө бэлэн мөнгөөр төлж, баримт гаргуулж авна уу. Сургалт хариуцсан ажилтан тухайн баримтыг хүлээн авч, таны төлсөн төлбөрийн мөнгөн дүнг буцаан төлөх болно.

2. Сургалтын координатор эсвэл өөр бусад ажилтан таныг эмнэлэг юм уу клиник рүү дагуулж явна.

Эмчид үзүүлэх шаардлагатай тохиолдолд, аливаа хэлний асуудлаас зайлсхийх үүднээс, Сургалтын координатор, ЖАЙКА-гийн Ресепшнтэй холбоо барьж, ЖАЙКА-гийн ажилтантай хамт явна уу.

Ресепшн болон Эрүүл мэндийн зөвлөгөө өгөх өрөөнд эм хадгалдаггүй.




VI. Онцгой байдлын процедур

ЖАЙКА Кансай нь, зочдын бүх өрөөнүүдэд тавьсан гал түймрийн үеийн заавар гэх мэт гал түймрийн эсрэг төрөл бүрийн зүйлсээр бүрэн тоноглогдсон.

Бид таныг, буудалд бүртгүүлснийхээ дараа аль болох эрт ЖАЙКА Кансай-ын аюулгүй байдлын онцлогийг олж мэдэн, байрлаж байгаа давхрынхаа аваарын гарцны байршлыг мэдэж авахыг зөвлөж байна.

Онцгой байдлаас өөр бусад үед тагтан дээр гарахгүй байхыг анхааруулъя.



Зочдын өрөөнүүдийн давхрын схем (5-р давхар)



Өрөөндөө орохдоо

Дүрвэх замыг мэдэж авна уу.

Давхар болгоны хоёр захад байгаа аваарын гарцны байршлыг мэдэж авна уу.



Гал түймрээс сэргийлэх үүднээс:

Лаа болон хүж БҮҮ АСАА.

Зочдын өрөөнд хоол БҮҮ ХИЙ.

Хувцсаа чийдэнгийн бүрхүүл дээр БҮҮ ТАВЬ.



Гал т үймрийн үеийн аюулг үй байдлыг хангах мэдээлэл

Хэрвээ та гал түймэр гарч байгаатай таарвал:

Тайван байж, юуны өмнө Ресепшн руу ярь.



"Гал түймэр (Fire)" эсвэл "Авраарай (Help)" гэж хашгир.



Гал түймрийн үед дүрвэхдээ:

Аль болох түргэн хамгийн ойрхон байгаа аваарын гарц руу яв.

Лифт БҮҮ ХЭРЭГЛЭ.



Норгосон нусны алчуур юм уу гар нүүрийн алчуураар ам хамраа хааж барингаа, доош бөхий, эсвэл мөлх.



Аваарын гарц



Гал унтраагч



Зүүн: Яаралтай дуудлагын утас
Баруун: Дохиоллын товчлуур
Доод: Галын хоолой



Зүүн: Шүршигч
Баруун: Халуун болон
Утаа мэдрэгч

Газар хөдлөлтийн үеийн аюулг үй байдлыг хангах мэдээлэл

Хэрвээ газар хөдөлөв өл:


ЖАЙКА Кансай дотор байгаа үед, ЖАЙКА-гийн ажилтны зааврыг дагана уу.

ЖАЙКА Кансай-аас гадуур байгаа үед:

Тайван бай! Хамгийн аюулгүй газрыг олж тогтоон, тэр газар руугаа болгоомжтойгоор хөдөл. Газар хөдлөлтийн үеийн хөдөлгөөн тасралтгүй үргэлжилдэггүй, аюулгүй байрлал олоход чичиргээ хоорондын хугацааг шаламгай ашигла.


Тамхи болон бусад аливаа галыг даруй унтраа.

Цахилгаан хэрэгслүүдийг даруй унтраа, эсвэл цахилгаанаас бүрмөсөн салга.



Ямар ч цонхноос хол байж, өрөөний булан юм уу, эсвэл ширээн доор орж, өөрийгөө хамгаал. Толгой болон нүүрээ бэртээхээс сэргийлж, ямар нэг юмаар халхал.


Тахийх юм уу бөглөрчихөөс нь өмнө хаалгаа онгойлгож, гарах гарцаа чөлөөл.



Гадагшаа гарах гэж БҮҮ ЯАР. Цонх, гулсдаг шилэн хаалга, толиноос хол бай.

Унаж ирэх, савчих магадлалтай аливаа юмнаас зайлсхий.

Доргилтын дараах түлхэлтийн нөлөөгөөр, барилгын нурангийн хэлтэрхий болон бусад юмнууд унаж ирэх магадлалтай тул, дүрвэх үедээ болгоомж сэрэмжтэй бай.



Гал түймэр, газар хөдлөлтийн аль ч тохиолдолд, холбогдох ажилтны зааврыг дагана уу.

Харилцааны хөтөлбөрүүд - Спорт, Японы соёл -

ЖАЙКА КАНСАЙ-аас та бүхэнд Сайн дурын Япон хүмүүстэй Харилцааны хөтөлбөрүүдэд оролцохыг санал болгож байна.

Уг хөтөлбөрүүд нь, Японы соёл, нийгэм, амьдралын хэв маяг болон бусад олон зүйлсийн талаар ойлголт авах үнэтэй боломж юм. Сайн дурын Япон хүмүүс та бүхэнтэй хамтдаа нэгэн хөгжөөнтэй цагийг өнгөрөөхөөр тэсэн ядан хүлээж байна. Соёлын хөтөлбөрт оролцоход, хамгийн шинэ цагийн хуваарийг харж, Ресепшн дээр урьдчилан бүртгүүлнэ үү.

*** Спортын арга хэмжээнүүдэд оролцоход бүртгүүлэх шаардлагагүй.**

* Цагийн хуваарь нь урьдчилан

мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөх магадлалтай.

★Оролцох төлбөр: **Үнэ төлбөргүй**

СПОРТЫН ХӨТӨЛБӨР

Үйл ажиллагаа	Цаг	Хаана	Цагийн хуваарь
 Волейбол	18:30-21:00	Биеийн тамирын заал (2-р давхар)	(11-р сараас 4-р сар) 1 дэх, 4 дэх Пүрэв гариг / Сар бүр (5-р сараас 10-р сар) 1 дэх, 4 дэх Пүрэв гариг, 3 дахь Даваа гариг / Сар бүр
 Агаарын теннис	19:00-21:00	Биеийн тамирын заал (2-р давхар)	Лхагва гариг бүр / Сар бүр
 Сагсан бөмбөг	18:00-21:00	Биеийн тамирын заал (2-р давхар)	2 дахь, 4 дэх Мягмар гариг / Сар бүр
 Теннис	18:30-21:00	Теннисний талбай (4-р давхар)	3 дахь Мягмар гариг / Сар бүр
 Фитнесс	18:30-19:30	Биеийн тамирын заал (2-р давхар)	3 дахь Мягмар гариг / Сар бүр
 Футзал	10:00-15:00	Биеийн тамирын заал (2-р давхар)	3 дахь Ням гариг / Сар бүр

ЯПОНЫ СОЁЛЫН ХӨТӨЛБӨР

Үйл ажиллагаа	Цаг	Хаана	Цагийн хуваарь
Цэцгийн урлаг	10:00-11:30	Ориентешний өрөө 1+2 (2-р давхар)	4 дэх Бямба гариг / Сар бүр 
Япон бичгийн уран татлага	19:00-20:30	Ориентешний өрөө 1+2 (2-р давхар)	2 дахь, 4 дэх Лхагва гариг / Сар бүр
Цайны ёслолын урлаг 	10:30-12:00	Япон маягийн өрөө (4-р давхар)	1 дэх Ням гариг / Тэгш тоотой саруудад 
ЮКАТА өмсч үзэх (Японы уламжлалт хувцас)	10:00-11:30	Япон маягийн өрөө (4-р давхар)	2 дахь Ням гариг / Сар бүр 
Японы ардын бүжиг	18:30-20:00	Ориентешний өрөө 1+2 (2-р давхар)	2 дахь, 4 дэх Пүрэв гариг / Сар бүр 